



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/106

Улаан-Уул

Хууль бус ан агнуур болон тарваган тахал
өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 5.5.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ний өдрийн А/427 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/514 дүгээр захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1.Өлзийт сумд байгаль орчны гэмт хэрэг зөрчил гарахаас сэргийлэх, агнахыг хориглосон амьтныг хууль бусаар агнах, тээвэрлэх, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг худалдаалах, байгалийн голомтот болон мал амьтны гоц халдварт өвчин гарах, халдвар зөөгдөн орохоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны 08 сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл, нийт 76 хоногийн хугацаанд хууль бус ан агнуур болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Мөнхжаргал), экологийн байцаагч цагдаагийн дэслэгч (Д.Цэрэннадмид), Байгаль хамгаалагч, багийн Засаг нарт үүрэг болгосугай.

2.Хяналт, шалгалт зохион байгуулах төлөвлөгөө, зардлыг хавсралтаар баталсугай.

3.Сумын пост, хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

642201211